

Сэтгэл ханамжийн судалгаа 2025 оны жилийн эцсийн тайлан


Судалгааг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07-р сарын 01 өдрийн А/346 тоот тушаал гарсантай холбоотойгоор эмнэлгийн байгууллага нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ болон эмч, эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн үнэлгээг байгууллагын онцлогт тааруулан боловсруулан гаргах болсонтой холбоотойгоор 2024 онд Улсын хоёрдугаар төв эмнэлгээс дахин боловсруулсан асуумжийн дагуу авсан. Амбулаториор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн асуумж нь 13 асуулттай. Хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн асуумж нь 14 асуулттай. Эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн асуумж нь 7 бүлэг, 26 асуулттай судалгааны асуумжаар, цахим хэлбэрээр авлаа.

2025 оны жилийн эцсийн байдлаар “Амбулаториор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд” нийт 477 үйлчлүүлэгч судалгаанд хамрагдсан. Нэгдүгээр улиралд-109 үйлчлүүлэгч, хоёрдугаар улиралд-129 үйлчлүүлэгч, гуравдугаар улиралд-129 үйлчлүүлэгч, дөрөвдүгээр улиралд- 110 үйлчлүүлэгч тус тус хамрагдсан байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар “Хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд” нийт 495 үйлчлүүлэгч судалгаанд хамрагдсан. Нэгдүгээр улиралд-104 үйлчлүүлэгч, хоёрдугаар улиралд-141 үйлчлүүлэгч, гуравдугаар улиралд-130 үйлчлүүлэгч, дөрөвдүгээр улиралд- 120 үйлчлүүлэгч тус тус хамрагдсан байна.

2025 оны 1,2,3,4 дүгээр улирлын байдлаар Амбулаторийн ерөнхий сэтгэл ханамжийн хувь 80.8%(маш сайн, сайн), Хэвтэн эмчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамжийн хувь 96.2% (маш сайн, сайн) байна. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр ажил сайжруулах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

1. Амбулаторийн ерөнхий сэтгэл ханамжийн хувь 80.8% (маш сайн, сайн). 2025 оны 1,2,3,4 дүгээр улирлын байдлаар графикаар харьцуулбал:



2. Хэвтэн эмчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамжийн хувь 96.2% (маш сайн, сайн). 2025 оны 1,2,3,4 дүгээр улирлын байдлаар графикаар харьцуулбал:



ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТАН БОЛОН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭЭС АВСАН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ МӨРӨӨР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Нэг. Амбулаториор үйлчлүүлэгдээс авсан сэтгэл ханамжийн судалгаа

1. Үйлчлүүлэгчийн хүлээгдлийг бууруулах ажлын хүлээнд дараах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:
 - Дотоод шүүрлийн булчирхайн үзлэгийн 2 кабинетын дунд зөвлөгөө мэдээллийн хэсэг бий болгосон. Тухайн хэсэгт 2-р курсийн резидент эмчийн хяналтад дор суулгаж үйлчлүүлэгчид зөвлөгөө мэдээллийг өгч ажиллаж байна. Мөн сар болгоны эм, тарианы жорыг цахим болгосноор үйлчлүүлэгчид чирэгдэлгүй болсон.
 - Чихрийн шижин өвчнийг эмчлэх, иргэдэд цогц эмчилгээ үйлчилгээ үзүүлэх зорилгоор Диабетийн төвийг ашиглалтанд оруулж ажиллаж байна.
 - Хоол боловсруулахын үзлэгийн 2 кабинет 2 чиглэл болгож ангилснаар хүлээгдэл тодорхой хувиар буурсан. (Элэг, цөс, нойр булчирхай болон ходоод)
 - Мэдрэл судлалын үзлэгийн 2 кабинет 4 болгон өргөтгөсөн. 2 кабинетад 2 үндсэн эмчийн үзлэг, үлдсэн 2 кабинетад 2-р курсийн резидент эмч нарыг эмчийн хяналтад дор үзлэг, зөвлөгөөг өгч ажиллаж байна. Ингэснээр үйлчлүүлэгчийн хүлээгдэл тодорхой хувиар буурсан.

- Мөн Эмнэлгийн үйл ажиллагаа зохицуулалтын тасаг амбулаторид сууж буй эмч нарт хяналт тавьж ажиллаж байна. (Үзлэгийн цагтаа үзэж буй эсэх,)
 - 2025 оны 05 сарын 12-ноос эхлэн Арьс судлалын эмч, Цус судлалын эмч, Ахмадын эмч нар өдөрт тус бүр 5 үйлчлэх хүрээний ахмадуудыг дуудан хяналтын үзлэг оношилгоог оочир дараалалгүй хийж үйлчилж байна. Ингэснээр үзлэг оношилгооны хүлээгдэл буурна.
2. Харилцаа хандлагыг сайжруулах ажлын хүрээнд Ёс зүйн хороог байгуулан ажиллаж байна.

Хоёр. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдээс авсан сэтгэл ханамжийн судалгаа

1. 50 орт барилгын засварыг хийх ажлын хүрээнд тендер зарлан засвар үйлчилгээний ажил хийгдэж байна.
2. Цэвэрлэгээ, засвар үйлчилгээтэй холбоотой 2025 оны 05 сарын 01-нд Эмнэлгийн захирлын А/110 тоот тушаалаар “Нэгжийн удирдлагын түр журам” гарган шинэ зохион байгуулалтад шилжин ажиллаж байна. Ингэснээр нэгжийн хэмжээнд нэгдсэн удирдлага зохион байгуулалтыг хангах буюу нэгжийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, хадгалалтад хяналт тавих, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангуулах, байрны тохижилт, цэвэрлэгээ, ногоон байгууламжийн бүрэн бүтэн байдал үйлчилгээний чанарт хяналт тавих, байгууллагын барилга, байгууламж, дотоод гадаад орчны засвар үйлчилгээ зэргийг хэрэгжүүлэн ажиллах ба өдөр тутмын хэрэглээ түүний чирэгдэл, аюулгүй байдал, дотоод зохион байгуулалтыг хэрэгжүүлэх хүрээнд байршуулалтын агуулах хариуцан ажиллах зэрэг нэгжийн бүхий л үйл ажиллагааг зохицуулан ажилснаар цэвэрлээ үйлчилгээ, урсгал засвар гэх зэрэг ажлуудыг хариуцан ажиллах шинэ зохион байгуулалтад шилжин сайжруулахаар ажиллаж байна.
3. Хэвтэн эмчлүүлэх орны хүлээгдэл бууруулахтай холбоотой ажлын хүрээнд дараах ажлыг зохион байгуулж байна. Үүнд:
 - Эмнэлгийн захирлын 2025 оны 04 сарын 10-ний А/85 тоот “Хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээнд ашиглах ор, нөхцөл сайжруулсан орны тоог шинэчлэн батлах тухай” тушаалыг шинэчлэн баталсан.
 - Эмнэлгийн захирлын 2025 оны 04 сарын 16-ний А/90 тоот “Улсын хоёрдугаар төв эмнэлгийн орны зохицуулалтын түр журам” тушаал баталсан. Хэвтэн эмчлүүлэх тасгийн орны зохицуулалт, орны хуваарилалтыг оновчтой хийх замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үр ашигтай хүргэх, өвчтөнийг эмнэлэгт хэвтүүлэх,

гаргах үйл явцыг зөв зохион байгуулж, оны хүлээгдлийг багасган, орны нөөцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:


ЭМТҮЧАБ-ЫН АЛБАНЫ ЛАВЛАГААНЫ АЖИЛТАН



Э.НОМИН-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:

ЭМТҮЧАБ-ЫН АЛБАНЫ ДАРГА



З.АРЪЯАСҮРЭН